



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 12

Өмнөдэлгэр сум

**Хүүхэд хамгааллын хамтарсан багийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам"-ын 2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит Тавдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хамгаалах чиг үүрэг бүхий хамтарсан багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Хамтарсан багийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, багийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх, багаа тогтвортой ажиллах нөхцөлийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Р.Энхтөр)-д, ажлыг хагас, бүтэн жилээр төлөвлөн хэрэгжүүлж, тайланг сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлж ажиллахыг сумын хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Г.Мөнхзул)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/08 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

D.disc /alban bichig/ ITH togtool

Өмнөдэлгэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Тавдугаар
хуралдааны 12 дугаар тогтоолын хавсралт

ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН
ХАМТАРСАН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Хамтарсан багийн ахлагч:	Сумын Засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан
Гишүүд:	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Наран багийн Засаг дарга
	Баянзүрх багийн Засаг дарга
	Хэнтий багийн Засаг дарга
	Талын булаг багийн Засаг дарга
	Чандган багийн Засаг дарга
	Төвийн багийн Засаг дарга
	Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
	Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан
	Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйч
	Хүүхдийн цэцэрлэгийн арга зүйч
	Хүүхдийн цэцэрлэгийн сэтгэл зүйч
	Хэсгийн төлөөлөгч
	Цагдаа